



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

᠑᠐᠑1 оны 03 сарын 0᠑ өдөр

Дугаар А/᠑᠐.

Мандалговь

Ахмадад ээлтэй сум, баг, байгууллага  
шалгаруулах журам шинэчлэн батлах тухай

Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.5.2 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 389 дүгээр тогтоолоор батлагдсан "Ахмад настны хөгжил хамгааллын үндэсний хөтөлбөр"-ийн 4.1 дэх заалт, Монголын Ахмадын Холбооны Ерөнхийлөгчийн 2020 оны 23 дугаар захирамж, Аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 3.4.2.1 дэх арга хэмжээ, Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.4.3 дахь арга хэмжээ, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2021 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 05 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Ахмадад ээлтэй" сум, баг, байгууллага, аж ахуйн нэгжийг шалгаруулах журмыг хавсралтаар баталсугай.
2. Ахмадын байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг туслалцаа үзүүлж, ахмад настны талаар авах арга хэмжээг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж ажиллахыг сум, баг, байгууллага, аж ахуйн нэгжийн дарга, эрхлэгч нарт үүрэг болгосугай.
3. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж сум, баг, байгууллага, аж ахуйн нэгжээс ирүүлсэн тодорхойлолтод хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, дүнг аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (А.Нарантуяа), Ахмадын хороо (Ц.Сугир) -д үүрэг болгосугай.
4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2017 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/493 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

481210753